



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар 4/502

Номгон

Коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан  
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын 2021 оны 05 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, иргэд олон нийтийг эрүүл мэндээ хамгаалах хандлагыг дээшлүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Маскаа зүүцгээе” аяныг 2021 оны 08 дугаар сарын 9-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2.“Маскаа зүүцгээе” аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 1 дүгээр, байгууллагуудын ажиллах хуваарийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Амны хаалтын нөөцийг бүрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт, өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш ажилчдыг урьдчилан сэргийлэх арга хэмжээнд татан оролцуулахыг Боловсрол, соёл урлагийн газар (Ц.Энхтөр)-т үйл ажиллагаа зохион байгуулах явцад үүргээ биелдүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд эхний удаад сануулах, зөрчлийг давтан гаргасан тохиолдолд хариуцлага тооцож ажиллахыг Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Оюутболд)-т, Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), амны хаалт зүүгээгүй иргэн (насанд хүрсэн хүн, хүүхэд)-д төрийн болон бусад төрлийн үйлчилгээ үзүүлэхгүй байхыг аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.


ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

10 1011 1011 1011

DA:2021 Захирамж-2021 он\Захирамж-2021 он.docx

601210159

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн А/502 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт




**УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтран ажиллах байгууллага
1	Коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө гаргах	2021.08.09	Онцгой байдлын газар АССУСАХМэргэжилтэн д/ч Б.Буяндэлгэр	Онцгой байдлын газар
2	Шуурхай штабын бүрэлдэхүүнийг хуралдуулж, Коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг танилцуулах	2021.08.10 11:00 цагт	Онцгой комиссын нарийн бичгийн дарга, дэд хурандаа Э.Батбаяр	
3	Коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг чанга яригчаар дамжуулж, зөвлөмж өгч, амны хаалт зүүж хэвшихэд хяналт тавих	2021.08.10 2021.08.31	Аймгийн Онцгой комиссын "Шуурхай ажлын хэсэг"	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд
4	Сумдын Засаг дарга нарт коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх хугацаатай албан бичиг хүргүүлэх	2021.08.10	Онцгой байдлын газар ГЭУҮХМэргэжилтэн д/ч Д.Энхсайхан	Онцгой байдлын газар
5	Үйлчилгээний төвүүдээр үйлчлүүлж байгаа иргэдэд амны хаалт зүүхэд хяналт тавих	Өдөр бүр	Мэргэжлийн хяналтын газар	Аймгийн Онцгой комиссны шуурхай штаб
6	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх	Өдөр бүр	Онцгой байдлын газар АССУСАХМэргэжилтэн д/ч Б.Буяндэлгэр	Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагууд
7	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн коронавируст (Ковид-19) халдвараас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдалд хяналт тавих	2021.08.16 2021.08.31	Мэргэжлийн хяналтын газар	Боловсрол, соёл урлагийн газар
8	Тайлан мэдээг нэгтгэж, үр дүнг аймгийн Онцгой комисст танилцуулах	2021.09.29	Онцгой байдлын газар	Аймгийн Онцгой комиссны шуурхай штаб

-----oOo-----

Аймгийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 09-ны  
өдрийн А/502 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

Д/д	Хариуцах албан тушаалтан	Хуваарилагдсан нутаг дэвсгэр
1	Онцгой байдлын газар	Гэгээн шавь 6 дугаар баг
2	Цагдаагийн газар	Түйн голын эрэг дагуу
3	Мэргэжлийн хяналтын газар	Номгон 1 дүгээр баг Рашаант 10 дугаар баг
4	Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар	
5	Эрүүл мэндийн газар	Дуурсах 3 дугаар баг
6	Мал эмнэлгийн газар	Угалз 4 дүгээр баг
7	Хүнс, хөдөө аж ахуйн газар	Цагаан чулуут 5 дугаар баг
8	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	Цахир 7 дугаар баг
9	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Есөнбулаг 9 дүгээр баг
10	Зэвсэгт хүчний 339-р анги	Эрдэнэмандал 2 дугаар баг
11	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл урлагийн газар	Эргүүл багш, ажилчдыг томилж, иргэдэд зөвлөмж тараах, хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр иргэдэд хүргэх
12	Сумдын Засаг дарга нар	Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд

-----oOo-----